



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх, цочимог халдварын тандалт, сэргийлэлт, голомтын ариутгал, дархлаажуулалтын асуудлыг хариуцан хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах;
2. Эмнэлгийн ажилтан, иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж, лавлагаа өгөх, халдварт өвчин, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн чиглэлээр тандалт, судалгаа, үнэлгээ хийж, эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш |
|---------------------------|---|--|--|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Дархлаажуулалт, халдварт өвчний талаар гарсан Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллах; 2. Дархлаажуулалт, халдварт өвчний талаар гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогыг хэрэгжүүлэх, тайлагнах; 3. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг дархлаажуулалт, халдварт өвчний чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах. | Хэрэгжилтийн хувь Хэрэгжилтийн хувь. Нэгдсэн бодлого, чиглэлийг хангасан эсэх | Г, Х Г, Х Г, Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Элэгний В, С вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, тархалтыг судлах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах; 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын эрсдэлийг тодорхойлон сэргийлэх, хянах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, эрсдэлийн үнэлгээ судалгааг хийж, ажиллах; 3. Амьсгалын замын халдварт өвчний чиглэлээр хэрэгжиж буй тогтоол, тушаал, заавар, журмыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах; | В,С вирусын тархалтын түвшин Эмнэлгээс шалтгаалсан халдвар Өвчлөлийн үзүүлэлт Мэргэжил арга зүйгээр хангагдсан эсэх | Г, Х, Т Г Х, Т |

| | | |
|---|-------------------------------------|---------|
| <p>4. Халдварт өвчний чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн батлуулж, холбогдох байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангах, хэрэгжүүлэх, тайлагнах;</p> <p>5. Халдварт өвчний талаар мэдээллийн сан байгуулах, баяжуулах ажлыг зохион байгуулах;</p> <p>6. Халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;</p> <p>7. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагч нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх;</p> <p>8. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд боловсролын байгууллагын үүрэг, оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p>9. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд бусад төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэний оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p>10. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, нийтэд түгээх;</p> <p>11. Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүд, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах;</p> <p>12. Дархлаажуулалтын хамралтын бодит байдал, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, дархлаажуулалтын ач холбогдлын талаар иргэдийн мэдлэг, хандлагын байдалд судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;</p> <p>13. Бэлгийн замаар дамжих халдвар, Дархлалын олдмол хомсдол өвчний урьдчилан сэргийлэх үзлэг</p> | Мэдээний сан бүрдсэн эсэх | Г |
| | Бэлэн байдал хангагдсан эсэх | Г |
| | Хамтын оролцоо хангагдсан эсэх | Г, Х, Т |
| | Хамтын оролцоо хангагдсан эсэх | Г |
| | Хамтын оролцоо хангагдсан эсэх. | Г |
| | Иргэдийн хандлагын өөрчлөлтийн ахиц | Г, Х, Т |
| | Хэрэгжилтийн хувь | Г, Х, Т |
| | БЗДХ-ын үзүүлэлт | Г, Х, Т |



| | | | |
|--|--|--|--|
| | шинжилгээг зохион байгуулж, өвчлөлийн түвшинг тогтоох, хавьтал судалгаа хийх, БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага, дадлын судалгаа хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх; 14. Сургууль, цэцэрлэгийн орчинд амьсгалын замын халдварт өвчин дэгдэх эрсдэлийг судалж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дэглэмийн хэрэгжилтэнд үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх; | Халдварт өвчний эрсдэл буурсан байна. | Г, Х, Т |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1. Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах; 2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; 3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах; 4. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх; 5. Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах; 6. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах; 7. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Ёс зүйн зөрчил гаргасан эсэх Ашиг сонирхлын зөрчилгүй гаргасан эсэх Хэрэгжилтийн хувь Биелэлтийн хувь Хэрэгжилтийн хувь Хэрэгжилтийн хувь Хэрэгжилтийн хувь | Г Г Г Г Г Г |
| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | | |
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | | |
| Мэргэжил | Анагаах ухаан /0912/, нийгмийн эрүүл мэнд /091801/. | | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх. | | |
| Туршлага | Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх. | | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | <ul style="list-style-type: none"> - Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - Нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - Бусад. | |

| | | |
|--|--------------------|---|
| | Асуудал шийдвэрлэх | <ul style="list-style-type: none"> - Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - Хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - Шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - Аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - Хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - Бүтээлч, санаачилгатай ажиллах; - Бусад. |
| | Багаар ажиллах | <ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - Багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - Багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - Үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Нээлттэй, шударга байх; - Бусад. |
| | Бусад | <ul style="list-style-type: none"> - Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - Зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - Шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - Компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах; - Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - Англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх. |

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга


| | |
|--|--|
| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
| Байхгүй | <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар - Эмнэлгийн ажилчид - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан - ЭМЯ-ны холбогдох мэргэжилтэн - Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн холбогдох |

| | |
|--|--|
| | <p>мэргэжилтэнүүд</p> <ul style="list-style-type: none"> - Халдварт өвчин судлалын үндэсний төв - Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан |
|--|--|

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| <p>Албан тушаал:</p> <p>УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА</p> <p>Б.АЗЖАРГАЛ</p> <p>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p> | <p>Байгууллагын нэр:</p> <p>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p>Шийдвэрийн огноо: 19 10 30</p> <p>Дугаар: 181</p> |

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

| | |
|---|---|
| <p>Байгууллагын нэр:</p> <p>АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР</p> <p>Шийдвэрийн огноо: <i>2019.12.26</i></p> <p>Дугаар: <i>1159</i></p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>ДАРГА <i>[Signature]</i> Р.ГАНДИЙМАА</p> <p>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p> |  |
|---|---|

-----oO-----